



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 05

Эрдэнэт хот

Г Тайлан баталгаажуулах тухай 7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/188 дугаар тушаал, "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг" гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг аймгийн ИТХ, Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар, ХББЗА ОНӨААТҮГ-т тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг холбогдох төсвийн шууд захирагчдаар арилгуулах, өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2018 оны 12 сарын 01-ний өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга Д.Батлутад зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг аудитын менежер /Б.Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

“Орон нутгийн төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” гүйцэтгэлийн аудитын тайлан

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ӨГӨӨЖИЙГ ТӨЛӨВЛӨН, ЗАХИАЛАГЧИЙН БОЛОН
ДОТООД ХЯНАЛТЫГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ, БИЙ БОЛСОН ҮР ӨГӨӨЖ, ҮР ДҮНГ
БОДИТОЙ ТООЦОХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.**

**Орхон аймаг
2018 он**

		АГУУЛГА	
Аудитыг гүйцэтгэсэн:		Товчилсон үгийн тайлбар	3
Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор:	Ц.Нармандах	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл	4
Аудитын менежер:	Б.Эрдэнэ	Бүлэг 1: Хөрөнгө оруулалтын ТАХ нь Засаг даргын мөрийн хөтөлбөртэй уялдсан хэдий ч зураг төсөвгүй хөрөнгө төлөвлөж баталсан байна.	6
Аудитор:	О.Дашжамц О.Гантуяа	1.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг Засаг даргын мөрийн хөтөлбөртэй уялдуулан төлөвлөсөн байна.	6
2018 оны 05 дугаар сар		1.2 Батлагдсан зураг төсөвгүй 1088.1 сая төгрөгийн төсөвтэй 15 төсөл, арга хэмжээг төлөвлөж, баталсан байна.	7
		1.3 Өмнөх онуудын хөрөнгө оруулалтын баталгааны хувь болох 34 ТАХ-ний 456.7 сая төгрөг, гүйцэтгэл дутуу 36 ТАХ-ний 3549.1 сая төгрөг, нийт 4005.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөгөөнд тусгасан байна.	8
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар 70357955 дугаарын утсаар харилцана уу.		Бүлэг 2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.	8
		2.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа 950.0 сая төгрөгийн 11 ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.	8
Уг тайланг Төрийн аудитын байгууллагын audit.mn цахим хуудаснаас үзнэ үү.		2.2 Гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй 30 гүйцэтгэгчдэд 23.9 сая төгрөгийн алдангийг тооцож ажилласан байна.	11
		2.3 Захиалагч гэрээний хэрэгжилтэнд тавих хяналтыг хэрэгжүүлж ажилласан ч зөрчил дутагдалтай ажлууд байна.	12
Хаяг: Орхон аймаг дахь Төрийн аудитын газар,		2.4 Хөрөнгө оруулалтын 384-н ТАХ-нд 18954.1 сая төгрөгийг төлөвлөснөөс 356-н ТАХ-нд 16435.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.	17
Нутгийн удирдлагын ордон Хүрэнбулаг баг, Баян-өндөр сум, Орхон аймаг, Монгол улс.		Бүлэг 3 Хөрөнгө оруулалтын өгөөжийг бодитой тооцож, үнэлээгүй байна.	20
		3.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл хөтлөлт хангалттай, ашиглалт 97.7 хувьтай байна.	20
		3.2 Хөрөнгө оруулалтад дотоод хяналт хийгдээгүй, эрсдлийн удирдлагаар хангагдаагүй байна.	21
		3.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, үр өгөөжийг бодитой тооцож, үнэлж дүгнэх шаардлагатай байна.	21
		Дүгнэлт, зөвлөмж	22
		Алдаа зөрчлийн нэгтгэл	23

УИХ	Улсын их хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ТАХ	Төсөл арга хэмжээ
ХББЗА	Хот байгуулалт, барилга захиалагчийн алба
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчийн хурал
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ХА	Харьцуулалтын арга
ШХА	Шууд худалдан авалт
ХТШ	Хязгаарлагдмал тендер шалгаруулалт
ХК	Хувьцаат компани
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
ИШС	Инженерийн шугам сүлжээ
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ЦЭХ	Цахилгаан эрчим хүч
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ТББ	Төрийн бус байгууллага
ШУТП	Шинжлэх ухаан технологийн парк
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл:

1. **Аудит хийх үндэслэл:** Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөө” -г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.
2. **Аудитын зорилт:** “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.
Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд:
 - Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх;
 - Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх;
 - Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын өгөөжийг бодитой тооцож, үнэлсэн эсэх;
3. **Аудитын хамрах хүрээ:** Аудитад орон нутгийн төсвөөс 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын 384 төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг болон эдгээр төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэгчдийн үйл ажиллагааг хамрууллаа.
4. **Аудитын арга зүй:** Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах бөгөөд шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.
5. **Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:** Аудитад дараах хууль, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:
 - Барилгын тухай хууль,
 - Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт,
 - Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
 - Төсвийн тухай хууль,
 - Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
 - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
 - Төрийн албаны тухай хууль,
 - Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”,

- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”
6. **Аудит хийсэн бүрэлдэхүүн:** Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, аудитын менежер Б.Эрдэнэ үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн аудитын баг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.
 7. **Аудитын тайлан, баталгаажуулалт:** Аудитыг 2017 оны 3 сарын 2-ны өдрөөс 5 дугаар сарын 30-ны хооронд хийж гүйцэтгэн холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүллээ.

Ерөнхий мэдээлэл

Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 02 дугаар тогтоолоор орон нутгийн хөрөнгө оруулалтын зардалд 11902.8 сая төгрөг баталсан байна. 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн ээлжит 5 дугаар хуралдаанаар төсөвт тодотгол хийж орон нутгийн хөрөнгө оруулалтыг 7355.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн бол 2017 оны 12 сарын 01-ний өдрийн 9 дүгээр хуралдаанаар 303.9 сая төгрөгөөр бууруулж 18954.1 сая төгрөг зарцуулахаар батлагдсан байна.

Орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээс 136 төсөл, арга хэмжээнд 6985.9 сая төгрөг, Авто замын сангийн хөрөнгөөр нийт 7 ажилд 607.7 сая төгрөг, Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 39 төсөл, арга хэмжээнд 752.8 сая төгрөг зарцуулахаар төсөвт тусгагдсан байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орон нутгийн хөрөнгө оруулалтын авто зам, үер ус шуудууны шинэчлэлийн 26 ТАХ-нд 1586.5 сая төгрөг, инженерийн шугам сүлжээний шинэчлэлт, засварын 8 ТАХ-нд 1319.6 сая төгрөг, гэрэлтүүлэг цахилгааны 17 ТАХ-нд 641.5 сая төгрөг, барилга засварын 77 ТАХ-нд 3223.9 сая төгрөг, шинээр хийх барилга угсралтын 1 ажилд 2425.8 сая төгрөг, тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авах 48 ТАХ-нд 1951.2 сая төгрөг, нийт 177 ТАХ-нд 11148.5 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар тусгагдсан байна.

Мөн Эрүүл мэндийн 15 төсөл хөтөлбөрт 269.1 сая төгрөг, нийгмийн хамгаалал, халамж үйлчилгээний 8 төсөл хөтөлбөрт 334.2 сая төгрөг, гэр бүл залуучуудын 8 төсөл хөтөлбөрт 91.6 сая төгрөг, боловсролын 12 төсөл хөтөлбөрт 195.4 сая төгрөг, хүнс хөдөө аж ахуйн 9 төсөл хөтөлбөрт 43.2 сая төгрөг, барилга, үйлдвэр үйлчилгээний 9 төсөл хөтөлбөрт 189.5 сая төгрөг, төсөв санхүүгийн 4 төсөл хөтөлбөрт 12.0 сая төгрөг, төрийн захиргааны албан хаагчдын 5 төсөл хөтөлбөрт 165.0 сая төгрөг, хууль эрхзүйн 9 төсөл хөтөлбөрт 42.3 сая төгрөг, батлан хамгаалах 3 төсөл хөтөлбөрт 20.0 сая төгрөг, шилжих үлдэгдлээс санхүүжигдэх 23 төсөл хөтөлбөрт 1058.9 сая төгрөг, байгал хамгаалах сангаар 31 төсөл хөтөлбөрт 268.7 сая төгрөг, нийт 136 төсөл хөтөлбөрт 2961.5 сая төгрөг батлагдсанаас, 135 төсөл хөтөлбөр хэрэгжиж, 2859.6 сая төгрөг зарцуулагдсан байна.

2017 оны хөрөнгө оруулалтаар хийгдсэн 236 ТАХ-ний 13595.9 сая төгрөгийн хөрөнгийг санхүүгийн тайланд бүртгэхээс Орон нутгийн өмчийн газар нь 100 хувь буюу 13595.9 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн байна.

Бүлэг 1. Хөрөнгө оруулалтын ТАХ нь Засаг даргын мөрийн хөтөлбөртэй уялдсан хэдий ч зураг төсөвгүй хөрөнгө төлөвлөж баталсан байна.

1.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг Засаг даргын мөрийн хөтөлбөртэй уялдуулан төлөвлөсөн байна.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 02 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийг батлахдаа орон нутгийн хөрөнгө оруулалтыг анх 206 ТАХ-г 10622.5 сая төгрөгөөр гүйцэтгэхээр баталсан ба 3 удаа тодотгон 202 ТАХ-г 10607.8 сая төгрөг болгон баталжээ. Мөн орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээс 136 төсөл арга хэмжээнд 6985.9 сая төгрөг, авто замын сангийн хөрөнгөөр 7 ТАХ-г 607.7 сая төгрөг, Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 39 ТАХ-г 752.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр ИТХ-аар баталсан байна. 2017 оны Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын батлагдсан төсвийн дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулбал:

№	Ажлын төрөл	нэр	Баталсан төсөв 2016-12-02 №02	Өөрчлөлт	/сая.төг/		
					Тодотгосон 2017-02-17 №02 тогтоолын дүн	Өөрчлөлт	Тодотгосон 2017-12-01 №09 тогтоолын дүн
1	Орон нутгийн хөрөнгө оруулалт		10622.5	113.9	10736.4	-128.7	10607.7
2	Авто замын сан		607.6		607.6		607.7
3	Байгаль хамгаалах сан		672.7	80.1	752.8		752.8
4	Шилжих үлдэгдлээс санхүүжих			7161.1	7161.1	-175.2	6985.9
5	Нийт дүн		11902.8	7355.1	19257.9	-303.9	18954.1

Нийт батлагдсан 18954.1 сая төгрөгийн 14323.1 сая төгрөгийг барилга, байгууламж, их болон урсгал засварын ажилд, 1669.7 сая төгрөгийг тоног төхөөрөмж худалдан авахад, 2961.3 сая төгрөгийг төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 02 дугаар тогтоолоор Болзошгүй аваарын зардлыг 113.9 сая төгрөгөөр, урд оны дуусаагүй ажлын үлдэгдэл буюу он дамжин хэрэгжих шилжих үлдэгдэлийг 7161.1 сая төгрөгөөр, байгаль хамгаалах сангаар хийгдэх 7 ажил, 11 төсөл хөтөлбөрийг 80.1 сая төгрөгөөр, нийт 7355.1 сая төгрөгөөр хөрөнгө оруулалтын ажлын төсвийг нэмж баталсан бол 2017 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор Болзошгүй аваарын зардлаас 70.3 сая төгрөг, бусад төсөл арга хэмжээнээс 58.4 сая төгрөгийг, шилжих үлдэгдлээс 175.2 сая төгрөгийг, нийт 303.9 сая төгрөгийг хасаж, 2017 онд хөрөнгө оруулалтын зардалд нийтдээ 18954.1 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

Орхон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөөг дараах 9 чиглэлээр хэрэгжүүлэхээр баталсан байдаг.

- Эрүүл-аз жаргалтай иргэд
- Нийгмийн дэмжлэгтэй- аз жаргалтай иргэд
- Ажилтай- аз жаргалтай иргэд
- Оюунлаг, ёс зүй, соёлтой-аз жаргалтай иргэд
- Эрүүл хүнс, цэвэр орчинтой-аз жаргалтай иргэд
- Сайхан хотын-аз жаргалтай иргэд

- Аялал жуулчлалын өгөөжтэй-аз жаргалтай иргэд
- Эдийн засгийн өсөлттэй-аз жаргалтай иргэд
- Чадварлаг засаглалтай-аз жаргалтай иргэд гэсэн 9 чиглэл

Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөртэй уялдсан эсэхийг нягтлан үзэхэд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд:

- Оюунлаг, ёс зүй, соёлтой - аз жаргалтай иргэд чиглэлээр сургууль, цэцэрлэгүүдийн байрны засвар болон гадна тохижолтонд 565.8 сая төгрөг, тоног төхөөрөмжид 76.9 сая төгрөг, Рашаант, Цагаанчулуут, Уртын гол багуудын дунд 280 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг барьж эхлүүлэхэд 1900.0 сая төгрөг,
- Эрүүл- аз жаргалтай иргэд чиглэлээр БОЭТ болон сумдын ӨЭМТ-дэд тоног төхөөрөмж, нөхөн сэргээх эмчилгээ, лабораторийг сайжруулах тоног төхөөрөмж худалдан авахад 604.0 сая төгрөг, засвар үйлчилгээнд 188.8 сая төгрөг,
- Чадварлаг засаглалтай - Аз жаргалтай иргэд чиглэлээр багуудын Засаг дарга болон ИНХ-ын үйл ажиллагааг дэмжиж тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авахад 24.5 сая төгрөг,
- “Эмч дэд хөтөлбөр”, “Багш дэд хөтөлбөр”, “Эрдэнэтчүүд Эрдэнэтчүүддээ хайртай дэд хөтөлбөр” зэрэг төсөл хөтөлбөрүүд, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүд нь аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан төлөвлөсөн байна.

1.2 Батлагдсан зураг төсөвгүй 1088.1 сая төгрөгийн төсөвтэй 15 төсөл, арга хэмжээг төлөвлөж, баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 сарын 02-ны өдрийн 02 дугаар тогтоолоор 2017 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 129 барилга, засварын ажил баталсан байна. Үүнээс 1088.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 15 хөрөнгө оруулалтын ажлын зураг төсвийг 2017 онд буюу ИТХ-аар хөрөнгө оруулалтын жагсаалт батлагдсаны дараа хийлгэсэн байна. Үүнд:

/сая.төг/

№	Төсвийн дугаар	Зургийн дугаар	Төсвийн нэрс	Төсөвт өртөг
1	БЗА-27/2017	ББЗА-27/2017	Эрүүл мэндийн зам барих ажлын төсөв	67.0
2	БЗА-34/2017	ХББЗА-37/2017	Зэст баг, Орон сууцны 1-р хороололд хогийн сав хийх ажил	50.0
3	БЗА-35/2017	ХББЗА-38/2017	Оюут баг, Орон сууцны 2-р хороололд хогийн сав хийх ажил	50.0
4	БЗА-36/2017	ХББЗА-39/2017	Уурхайчин баг, Орон сууцны 3-р хороололд хогийн сав хийх ажил	50.0
5	БЗА-37/2017	ХББЗА-40/2017	Хүрэнбулаг баг, Орон сууцны 4-р хороололд хогийн сав хийх ажил	50.0
6	БЗА-38-1/2017	ХББЗА-42-1/2017	Бүрэнбүст баг, Орон сууцны хороололд хогийн сав хийх ажил	50.0
7	БЗА-38-2/2017	ХББЗА-42-2/2017	Уртбулаг баг, Орон сууцны хороололд хогийн сав хийх ажил	50.0

8	БЗА-39-1/2017	ХББЗА-41-1/2017	Согоот баг, Орон сууцны 6-р хороололын хогийн сав хийх ажил/А хэсэгт	50.0
9	БЗА-39-2/2017	ХББЗА-41-2/2017	Согоот баг, Орон сууцны 6-р хороололын хогийн сав хийх ажил/Б хэсэгт	50.0
10	БЗА-40/2017	ХББЗА-43/2017	Орхон аймаг, Хотын төвийн гудамжинд хогийн сав байрлуулах ажил	50.0
11	БЗА-41/2017	ХББЗА-47/2017	Төрийн байгууллагуудын оффисын зориулалтын байрны гадна тохижилтын ажил	75.0
12	БЗА-42/2017	ХББЗА-46/2017	Шанд, Даваат багийн Халуун усны засварын ажил	56.1
13	БЗА-44/2017	ХББЗА-48/2017	Гэр хороололын үерийн хамгаалалтын сувгийн засварын ажил	350.0
14	БЗА-50/2017	ХББЗА-50/2017	Орхон аймаг, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн засварын ажил	30.0
15	БЗА-59/2017	ХББЗА-23/2017*	Орхон аймаг, Хот тохижуулах газрын 30 авто машины гаражийн өргөтгөлийн ажил/эхний хэсэг/	60.0
	Нийт			1088.1

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29.4 “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” заалтыг зөрчиж байна.

1.3 Өмнөх онуудын хөрөнгө оруулалтын баталгааны хувь болох 34 ТАХ-ний 456.7 сая төгрөг, гүйцэтгэл дутуу 36 ТАХ-ний 3549.1 сая төгрөг нийт 4005.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөгөөнд тусгасан байна.

АИТХ-ын 2017 оны 02 сарын 17-ны 2 дугаар хуралдаанаар өмнөх оны шилжих үлдэгдлээс 2015-2016 онуудын гүйцэтгэл дутуу ажлуудад олгох 70 ТАХ-ны 4005.8 сая төгрөг, мөн тухайн онд шилжих үлдэгдлээс шинээр хэрэгжүүлэх 43 ТАХ-ны 1921.1 сая төгрөг, төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлэх 23 ТАХ-ны 1058.9 сая төгрөг нийт 136 ТАХ-нд 6985.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталжээ.

Харин он дамжин шилжиж санхүүжүүлэхээр батлагдсан 6985.8 сая төгрөгийг зарцуулахаас 10.1 сая төгрөгийн хэмнэлт гарч, 5869.9 сая төгрөг зарцуулж, 1105.8 сая төгрөг зарцуулаагүй үлдсэн байна.

Зарцуулаагүй үлдсэн 1105.8 сая төгрөгөөс их засварын 3 ТАХ-ны 41.9 сая төгрөг, 1 тоног төхөөрөмжийн 75.0 сая төгрөг, мөн барилгын их засварын 17 ТАХ-ний баталгааны 5%-ын үлдэгдэл 243.2 сая төгрөг, дуусаагүй ажлын үлдэгдэл 745.7 сая төгрөгийн үлдэгдлийг дараа онд шилжихээр болжээ.

Бүлэг 2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

2.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа 950.0 сая төгрөгийн 11 ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орон нутгийн хөрөнгө оруулалтын авто зам, үер ус, шуудууны шинэчлэлийн 26 ТАХ-нд 1586.5 сая төгрөг, инженерийн шугам сүлжээний шинэчлэлт, засварын 8 ТАХ-нд 1319.6 сая төгрөг, гэрэлтүүлэг цахилгааны 17 ТАХ-нд 641.5 сая төгрөг, барилгын засварын 77 ТАХ-нд 3223.9 сая төгрөг, шинээр хийх барилга угсралтын 1

ажилд 2425.8 сая төгрөг, тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авах 48 ТАХ-нд 1951.2 сая төгрөг, нийт 177 ТАХ-нд 11148.5 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар тусгагдсан байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан 177 ТАХ-ний худалдан авах ажиллагаанд мөрдсөн журмыг хүснэгтээр харуулбал: /сая.төгрөг/

№	Ажлын төрөл	Худалдан авах ажиллагааны журам							
		НТШ	Шалгарсан дүн	ХА	Шалгарсан дүн	ШХА	Шалгарсан дүн	ХТШ	Шалгарсан дүн
1	Авто зам засвар шинэчлэл	1	352.8	21	685.0	2	15.0	2	529.5
2	Инженерийн шугам сүлжээ	4	1184.9	3	115.8	1	7.3		
3	Гэрэлтүүлэг			17	641.5				
4	Барилгын их засвар	5	533.7	66	2569.7	6	112.7		
5	Шинэ барилга байгууламж	1	2402.5						
6	Тавилга эд хогшил	10	1256.0	26	609.2	12	86.0		
	Нийт	21	5729.9	133	4621.2	21	221.0	2	529.5

Өмнөх онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааг энэ оны худалдан авах ажиллагаатай харьцуулбал:

№	Тендер шалгаруулалтын төрөл	2016 он	2017 он	Өсөлт бууралт
1	Нээлттэй тендер шалгаруулалтын арга	42	21	-21
2	Хязгаарлагдмал тендер	0	2	2
3	Харьцуулалтын аргаар	132	133	1
4	Шууд худалдан авалт	18	21	3
	Нийт	192	177	-15

2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, үр дүнг www.shilendans.gov.mn, www.meps.gov.mn, www.e-procurement.mn, www.tender.gov.mn сайтуудад мэдээлсэн байна.

Худалдан авах ажиллагааг түүвэрчлэн аудит хийхэд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Тус бүр нь 350.0 сая, 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Гэр хорооллын үерийн хамгаалалтын суваг хийх" 2 ажилд хязгаарлалттай тендер шалгаруулалт явуулж ТБОНӨХБАҮХАТХуулийн 8.2 дахь "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ" гэсэн заалтыг зөрчсөн,
2. Тус бүр нь 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, нийт 450.0 сая төгрөгийн төсөв бүхий "Орон сууцны хорооллуудад хогийн сав хийх" 9 ажилд үнийн санал ирүүлэх урилга илгээгээгүй, ТБОНӨХБАҮХАТХуулийн 33.2.1 дэх "техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх" гэсэн заалтыг зөрчсөн,

3. Тоног төхөөрөмж худалдан авах дараах тендерүүдэд тоног төхөөрөмжийг зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авсан байна. Үүнд:
 - 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Өрхийн эрүүл мэндийн 3 төвүүдийг эргэлтийн авто машинаар хангах” ажилд 2018 оны 05 сарын байдлаар зар мэдээний цахим хуудсууд дээрх зах зээлийн үнэ 40 сая төгрөгийн үнэ бүхий 2 vitz, 1 arius суудлын автомашинуудыг 59.0 сая төгрөгөөр бэлтгэсэн,
 - 65.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “БОЭТ-д Наркозны аппарат /унтуулга/” нийлүүлэх ажилд 57.8 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн Aeon7200A аппаратыг харьцуулалт амжилтгүй болж шууд гэрээ байгуулахдаа 64.9 сая төгрөгөөр худалдан авсан.
4. 367.3 сая төгрөгөөр бэлтгэсэн 4-н ТАХ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д заасан “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, Сангийн сайдын 2016 оны 415-р тушаалын 4.21-т заасан “Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно” заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:
 - БОЭТ-д дижитал рентген оношилгооны аппарат авах тендерт нэг ч байгууллага тендер ирүүлээгүй, улмаар тендерт шаардсан техникийн үзүүлэлтээс бага 2014 онд үйлдвэрлэгдсэн, БОЭТ-д түрээсээр үйл ажиллагаа явуулж байсан компанийн өмнө нь ашиглаж байсан, хүчин чадал бага аппаратыг өрөөний засвартай хамт авсан,



Өмнө нь ашиглаж байсан рентгений хуучин тоног төхөөрөмжүүд

- 35.0 сая төгрөгийн өртөг бүхий "11-р цэцэрлэгийг уурын зуухтай болгох" ажил батлагдсаныг гадна ИШС болгон өөрчилж, гэрээ байгуулан 29.8 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн, нэр зөрүүтэй санхүүжилт олгогдоогүй,
- 40.0 сая төгрөгийн өртөг бүхий "Шүүхийн шинжилгээний албанд явуулын лаборатори" худалдан авах төсөвт батлагдсаныг 18.7 сая төгрөгөөр Sonata 7 суудлын автомашин, 16.9 сая төгрөгөөр лабораторид шаардлагатай багаж хэрэгсэл, 4.1 сая төгрөгөөр хурлын ширээ, компьютер, принтер зэрэг оффисын зориулалттай тавилга тоног төхөөрөмж худалдан авсан,

- 97.8 сая төгрөгөөр "Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах, бүтэц орон тоогоор ажиллуулан шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах" ажлын хүрээнд 63.0 сая төгрөгийг телевизийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, студийн өрөөний засварт зориулалтын дагуу зарцуулж, 34.7 сая төгрөгийг ЭМГ-ийн ажилчдын тавилга, ширээ сандал авч зориулалт бусаар зарцуулсан байна.

2.2 Гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй 30 гүйцэтгэгчдэд 23.9 сая төгрөгийн алдангийг тооцож ажилласан байна.

2017 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн нийт 384 ажлуудаас 30-н ТАХ гэрээт хугацаандаа хийгдээгүй байна. Эдгээр ажлуудад 23.9 сая төгрөгийн хугацааны алдангийг нийт санхүүжилтээс нь хасаж олгосон байна.Тухайлбал:

- Байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагчдын албаны иж бүрэн дүрэмт хувцас /өвөл, зуны/, хамгаалах хэрэгслийг шинэчлэх ажилд 69 хоногын алданги 1.8 сая төгрөг,
- "Орхон" цогцолбор сургуулийн гадна биеийн тамирын талбайд хиймэл зүлэг бүхий хөл бөмбөгийн талбай байгуулах ажилд 15 хоногын алданги 0.4 сая төгрөг,
- Орон сууцны 4-р хорооллын 10-р байрны 2-р блокийн дээврийн засварын ажилд 21 хоногийн алданги 0.2 сая төгрөг,
- Орон сууцны 4-р хорооллын 10-р байрны 3-р блокийн дээврийн засварын ажилд 25 хоногийн алданги 0.3 сая төгрөг зэрэг болно.

Хүснэгтээр харуулбал:

№	Ажлын нэр	/төгрөг/ Тооцсон алданги
1	Орон сууцны 1-р хорооллын 2-р байрны 3,7-р блокийн дээврийн засвар	137,250
2	Орон сууцны 2-р хорооллын 5-р байрны 1-р блокийн дээврийн засвар	392,974
3	Орон сууцны 3-р хорооллын ДГТ-2-р байрны 2-р блокийн дээврийн засвар	120,545
4	Орон сууцны 4-р хорооллын 10-р байрны 2-р блокийн дээврийн засвар	221,117
5	Орон сууцны 4-р хорооллын 10-р байрны 3-р блокийн дээврийн засвар	263,731
6	Орон сууцны 5-р хорооллын 18-р байрны 4-р блокийн дээврийн засвар	54,560
7	Орон сууцны 5-р хорооллын 6.7-р байрны дээврийн засвар	772,587
8	Орон сууцны 6-р хорооллын 10-р байрны 2.3.4-р блокийн дээврийн засвар	312,456
9	Шанд багийн 30-31-р гудамжны шороон зам сайжруулах	232,500
10	Рашаант баг. Шороон зам сайжруулах	6,500
11	БОЭТөвийн Гэмтлийн тасгийн засварын ажил	47,000
12	"Орхон" цогцолбор сургуулийн гадна биеийн тамирын талбайд хиймэл зүлэг бүхий хөл бөмбөгийн талбай байгуулах	430,500
13	Автобусны зогсоол, сүүдрэвч барих	247,547
14	Баянцагаан болон Говил багийг ЭДЦС ТӨХК-ний хойд хэсгээр холбох 1.195км,Яргуйт багт баригдах 7,9 км хатуу хучилттай авто зам /А-М цэг хүртэл 1506 км/-ын зураг төсөл боловсруулах	2,989,000
15	Эрдэнэ ,Дэнж багт баригдах1.5 км,Кувейт,Орхоны гудамжийг холбох 0.833 км хатуу хучилттай авто замын зураг төсөл боловсруулах	2,610,800
16	Холбооны уулзвараас Баян худалдааны төвийн уулзвар хүртэлхи авто замын засвар	3,182,182
17	Яргуйт баг. Овоотын хэсэгт 160 кВА дэд өртөө, 6/0 кВ-ын ЦДАШ барих ажлын дутуу санхүүжилт	82,137
18	Говил багийн Булагтын В хэсэгт халианаас хамгаалах шороон овоолго босгох	71,500
19	Онцгой байдлын харъяа Эрдэнэ багт байрлах гал унтраах ангийн тусгай зориулалтын автомашины гражийн барилга	11,7000
20	Кувейтийн гудамжны гэрэлтүүлэг шинэчлэх	80,000
21	ЭМНийгмийн даатгалын газрын дээврийн засвар	117,947

22	Төрийн байгууллагуудын оффисын зориулалтын байрны гадна талбайн тохижилт	712,500
23	16-р цэцэрлэгийн цонхны засвар	520,880
24	Мах, сүүнд антибиотик болон төмс хүнсний ногоонд байгаа пестецидийн үлдэгдлийг тодорхойлох биохимийн анализатор /багц-1/	317,213
25	БОЭТ-д Наркозны аппарат /унтуулга/	778,800
26	Улсын бүртгэл, оюуны өмчийн газарт архивын нягтруулсан шүүгээ авах	704,000
27	Байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагчдын албаны иж бүрэн дүрэмт хувцас /өвөл, зуны/, хамгаалах хэрэгслийг шинэчлэх.	1,791,033
28	Эрдэнэ ,Дэнж ,Уртын гол багуудыг холбох 2,1 км хатуу хучилттай авто замын зураг төсөл боловсруулах	2,318,000
29	Баянбулаг, Булаг багийг холбох 0.305км,Баянбулаг, Булаг ,Наран багийг холбох 0,701 км,Цагаанчулуут,Рашаант,Их залуу багийг холбох 0,762 км хатуу хучилттай авто замын зураг төсөл боловсруулах	1,982,500
30	Яргуйт багт баригдах 7.9 км хатуу хучилттай авто зам /N цэгээс Z цэг хүртэл 1.109 км,Q цэгээс T цэг хүртэл 0.996 км/-ын зураг төсөл боловсруулах	2,324,100
	ДҮН	23,995,859

2.3 Захиалагч гэрээний хэрэгжилтэнд тавих хяналтыг хэрэгжүүлж ажилласан ч зөрчил дутагдалтай ажлууд байна.

Аудитаар ОНХО-аар хийгдсэн 177 ажлын 10779.2 сая төгрөгийн ажлаас 6452.3 сая төгрөгийн 110 ажлыг түүвэрлэн аудит хийлээ.

2017 онд ХББЗА ОНӨААТҮГ нь захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж орон нутгийн хөрөнгө оруулалтын 7010.5 сая төгрөгийн 138 ажилд улсын комисс, 2623.7 сая төгрөгийн 9 ажилд техникийн комисс, нийт 147 ажилд хяналт хэрэгжүүлэн үүрэг даалгавар өгч ажилласан байна. 2017 оны жилийн эцсийн байдлаар 5079.6 сая төгрөгийн 10 ажил дуусаагүй байна.

ХББЗА нь 2017 оны хөрөнгө оруулалтын ажлын зохиогчийн болон техник хяналт, зураг төсвийн ажлын нийт 471.2 сая төгрөгийн зардлын санхүүжилт авахаас 208.9 сая төгрөгийг техник хяналт болон зураг төсвийн санхүүжилт авсан байна.

Хотын захирагчийн алба нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа хатуу хучилттай болон шороон зам, замын нөхөөс, тэмдэг тэмдэглэгээ, хамгаалалтын хашлага хийж гүйцэтгэх 20 ажил, барилга засвар гадна тохижилтын 10 ажил, орон сууцны дээврийн засвар, Бүрэн бүст баг болон шинээр газар авсан иргэдийг ЦЭХ хангах 0.4/ 22кв-ын 2 ЦДАШ барих ажил, гэр хорооллын 3 баг, Жаргалант сумын гадна ИШС-ний ажил, нийт 4637.4 сая төгрөгийн 35 ажил болон болзошгүй аваарын зардлаар хийгдэж байгаа ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аудитад хамрагдсан ажлуудаас 491.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 7-н ажил чанарын доголдолтой, ашиглалтын шаардлага хангахааргүй гүйцэтгэгдсэн байна. Үүнд:

- Гэр хорооллын 3-р сургуулийн барилгын засварын ажлыг 145.5 сая төгрөгөөр Деново ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулан гүйцэтгэсэн боловч улсын комисс ажиллаагүй, шалны хулдаасыг Солонгос улсын сайн чанарын LG брэндийн хулдаасаар солих байсныг 2 давхарын ангиуд болон коридорыг Хятад улсад үйлдвэрлэсэн нимгэн хулдаасаар наалт муу хийгдэж, хулдаас урагдаж цоорсон, үрчийсэн байна.



Зураг төсөвт тусгасан материалаар хийгдээгүй



3-р сургуулийн шаланд наасан хулдаас товойж, хууларсан байгаа байдал

- 4 дүгээр хорооллын 10-р байрны 3-р блокын дээврийн засварыг Ньюгранд Эрдэнэт ХХК 21.0 сая төгрөгөөр, 1 дүгээр хорооллын 14-р байрны 3-н блокын дээврийн засварыг Ногоон очир ХХК 19.4 сая төгрөгөөр гүйцэтгэж улсын комисс хүлээн авсан боловч оршин суугаа айлуудын дээврээс ус гоожиж, ажил чанаргүй хийгдсэн байна.



4-10 байрны 3 блокын дээврээс ус орсон байгаа байдал



1-14 байрны 2 блокын дээврээс ус орсон байгаа байдал

- Жаргалант сумын 3-р цэцэрлэгийн засварын ажлыг Ньюгранд Пропертиз ХХК 70.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажиллаж 2017 оны 08 сарын 31-нд урьдчилсан үзлэг ажиллан гэрлийн арын хэсгийг эмульсдэх, гал тогоонд тоноглолын газардуулгыг нормын дагуу хийх, гадна талын утасны бэхэлгээ хийх, цонхны тавцан солих, шалны плитаны уналтыг сайтар гаргах үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд авах шийдвэр гаргаж 09 сарын 11-нд ашиглалтанд хүлээн авсан байна. Шалны плитаны усны хаялаг, уналтыг гаргах үүрэг даалгаврыг гүйцэтгээгүй.



3-р цэцэрлэгийн гал тогооны өрөөний усны хаялгыг сайн гаргаагүй шалны зориулалтын плита наагаагүй

- 99.0 сая төгрөгийн гэрээ бүхий Талст билэг ХХК-ийн гүйцэтгэсэн “8 ш Автобусны зогсоол, сүүдрэвч барих” ажлын Согоот багт байрлуулах автобусны буудлын ажлыг 40%-тай гүйцэтгэж байхад байршлыг сольж зөөвөрлөж, Наран багт байрлуулахад үерийн усны Ф600-ийн бетонон хоолой буудлын талбайн доор суурилуулж шинээр чулуун өрлөг бетонон амсар хийн байршуулж 1.6 сая төгрөгийн магадлашгүй ажлын зардлаар гүйцэтгэсэн. Зураг төсөвт целлойдор сурталчилгааны самбар болон дотор нь гэрэлтүүлэг хийсэн нь хагарсан байдалтай байна.



Автобусны зогсоолын сурталчилгааны самбарын шил болон гэрэлтүүлэг хагарсан байдал

- 57.4 сая төгрөгийн гэрээ бүхий Бурхууд ХХК-ний гүйцэтгэсэн “Орхон цогцолбор сургуулийн гадна биеийн тамирын талбайд хиймэл зүлэг бүхий хөлбөмбөгийн талбай байгуулах” ажлын зураг, төсөвт бороо цасны ус зайлуулагч хийгдээгүйн улмаас зүлэгний наалт болон цагаан тэмдэглэгээнүүд хууларч алга болсон байна.



5-р сургуулийн хөлбөмбөгийн талбайн зүлэг зөөлөрсөн, цагаан наалт хууларсан байдалтай байна

- 79.0 сая төгрөгийн гэрээ бүхий Золотое руно ХХК-ний гүйцэтгэсэн “17 дугаар сургуулийн гадна биеийн тамирын талбайг иж бүрэн тохижуулах ажлын гар бөмбөгийн талбайн буух шатны хоёр тал бутарч эвдэрсэн байна.



17-р сургуулийн гадна газрын теннисний талбайн шатны хоёр тал хагарч, бутарсан байдал

Монгол улсын Засгийн газрын 73 дугаар тогтоолоор баталсан Барилга захиалагчийн дүрэм 3.1.4.-т “гүйцэтгэгч нь барилга байгууламжийн үе шатны ажлыг гүйцэтгэх явцад зураг төсөл, барилгын норм, дүрэм, техникийн нөхцөлийг зөрчиж, чанаргүй болон дутуу гүйцэтгэсэн

тохиолдолд түүнийг гүйцэтгэгчийн зардлаар засуулах, нөхөн хийлгэх, санхүүжилтийг зогсоох, учирсан хохирлыг төлүүлэх арга хэмжээ авах” гэсэн заалтыг хангалтгүй хэрэгжүүлсэн тул ХББЗА ОНӨААТҮГ-т чанарын шаардлага хангахгүй дээрх 7 ажлын 491.3 сая төгрөгийн ажлуудыг гүйцэтгэгч байгууллагаар дахин гүйцэтгүүлж хүлээн авах тухай албан шаардлага хүргүүллээ.

2017 онд төсөл хөтөлбөрөөр эрүүл мэндийн 15-н төсөл хөтөлбөрт 269.1 сая төгрөг, нийгмийн хамгаалал, халамж үйлчилгээний 8-н төсөл хөтөлбөрт 334.3 сая төгрөг, гэр бүл залуучуудын 8-н төсөл хөтөлбөрт 91.6 сая төгрөг, боловсролын 12 төсөл хөтөлбөрт 456.8 сая төгрөг, хүнс хөдөө аж ахуйн 9-н төсөл хөтөлбөрт 43.2 сая төгрөг, барилга үйлдвэр үйлчилгээний 9-н төсөл хөтөлбөрт 189.5 сая төгрөг, төсөв санхүүгийн 4-н төсөл хөтөлбөрт 12.0 сая төгрөг, төрийн захиргааны албан хаагчдын 5-н төсөл хөтөлбөрт 175.0 сая төгрөг, хууль эрхзүйн 9-н төсөл хөтөлбөрт 42.3 сая төгрөг, батлан хамгаалах 3-н төсөл хөтөлбөрт 20.0 сая төгрөг, шилжих үлдэгдлээс санхүүжигдэх 23-н төсөл хөтөлбөрт 1058.9 сая төгрөг, байгал хамгаалах сангаар 31-н төсөл хөтөлбөрт 268.7 сая төгрөг, нийт 133 төсөл хөтөлбөрт 2961.3 сая төгрөг батлагдсанаас 132 төсөл хөтөлбөр хэрэгжиж 2859.3 сая төгрөг зарцуулагдсан байна.

№	Төсөл хөтөлбөрийн чиглэл	Төсөл, хөтөлбөрийн тоо	Төсөв	Гүйцэтгэл	/сая.төг/ Үлдэгдэл
1	Эрүүл мэндийн чиглэлээр	15	269.1	246.5	22.6
2	Нийгмийн хамгаалал халамж үйлчилгээний чиглэлээр	8	334.3	370.4	-36.1
3	Гэр бүл хүүхэд залуучуудын чиглэлээр	8	91.6	83.4	8.2
4	Болвсрол, спорт, соёл урлагийн чиглэлээр	14	456.8	448.9	7.9
5	Хүнс хөдөө аж ахуйн чиглэлээр	10	43.2	42.9	0.3
6	Барилга үйлдвэр үйлчилгээний чиглэлээр	12	189.5	178.1	11.4
7	Төсөв санхүүгийн чиглэлээр	4	12.0	11.0	1.0
8	Төрийн захиргаа, албан хаагчдын чиглэлээр	6	175.0	165.3	9.7
9	Хууль эрх зүйн чиглэлээр	9	42.3	40.5	1.8
10	Батлан хамгаалах чиглэлээр	3	20.0	19.9	0.1
11	Шилжих үлдэгдлээс санхүүжих	20	1058.9	997.7	61.2
12	Байгаль хамгаалах сангаас	31	268.6	254.7	13.9
	Нийт	133	2961.3	2859.3	102.0

Эдгээр төсөл хөтөлбөрөөс түүвэрлэн аудит хийхэд 202.6 сая төгрөгийн 2 төсөл, хөтөлбөр үр дүн тодорхойгүй байна. Эдгээр нь:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны гүйцэтгэлийн ажиллагааны төлбөрт 79.1 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрөөс санхүүжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 4.1.16, 4.1.17 дахь заалтыг зөрчин, зориулалт бусаар зарцуулсан байна.
- Орхон аймаг төрийн мэдээллийн Erdenet.mn, itkh-orkhon.gov.mn цахим хуудастай мөн Facebook хуудас ажиллуулдаг. Харин хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээгээр дараах сонин, веб сайтуудад мэдээлэл бэлтгэн тавихад 2015 онд 72.0 сая, 2016 онд 70.8 сая төгрөг зарцуулж байсан бол 2017 онд 52.7 сая төгрөгийг нэмж 123.5 сая төгрөгийг зарцуулсан нь хэвлэл мэдээллийн байгууллагын чанар, иргэдэд хүрэх мэдээллийн хүртээмж, үр өгөөжийг тооцохгүйгээр зарцуулсан байна.

№	Хэвлэл мэдээллийн байгууллагуудын нэр	Гэрээний санхүүжилт
1	Эрдэнэт таймс сонин	12.5
2	Үгийн хүч ТББ	5.0
3	ММДДХ ХХК	7.0
4	Нар туссан цаг сонин	3.0
5	Очир роуд ХХК	5.0
6	Их Хөсөг ХХК	3.0
7	Макс арт ХХК	2.5
8	Номин макс ХХК	11.4
9	НМПР ХХК	1.5
10	Колорфилмс ХХК	6.0
11	Бунадо ХХК	5.0
12	Ишилан ХХК	4.0
13	Эр Жи ОР ХХК	1.5
14	Хөх ах ТББ	3.0
15	Нээлттэй хаалга сонин	1.5
16	Монголын мэдээ сонин	3.0
17	Фило ХХК	6.0
18	Эко хөгжлийн алхам ТББ	4.0
19	Монцамэ агентлаг	3.0
20	МСНЭ Орхон салбар	7.3
21	СИТИПИПИЭс сервис ХХК	4.8
22	СТР сервис ХХК	3.0
23	Хотын шуудан сонин	2.5
24	Дэвжих дэнс төгс шийдэл ТББ	4.0
25	Эдимүүн ХХЗ	3.5
26	Пиил оф монголиа сэтгүүл	2.5
27	Гэгээн далай ХХК	4.0
28	Ситиблессинг ХХК	4.0
	Дүн	123.5

Мөн Баян-Өндөр сумын ИТХ-д төлөөлөгчдийн ажлын хэрэгцээнд 31 Ipad бүртгэлтэй байдаг атал 2017 онд тэргүүлэгчдэд 12.2 сая төгрөгөөр 7 нөүтбүүк авч өгсөн нь шаардлагагүй хөрөнгө оруулалт болсон байна.

Дээрх зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Төсөл, хөтөлбөр болон тоног төхөөрөмжийн нийлүүлэлтэд захиалагчийн хяналт хангалтгүй, төсөл хөтөлбөрүүдэд санхүүжилтийг 80-аас 100 хувь урьдчилан олгодог байна.

2.4 Хөрөнгө оруулалтын 384-н ТАХ-нд 18954.1 сая төгрөгийг төлөвлөснөөс 356-н ТАХ-нд 16435.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Аймгийн ИТХурлын хуралдаанаар орон нутгийн төсвийн зардлыг 90.8 тэрбум төгрөгөөр баталсан бөгөөд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засвар, төсөл арга хэмжээний зардлыг 18.9 тэрбум төгрөгөөр баталсан нь нийт төсвийн зардлын 20.8%-ийг эзэлж байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 18954.1 сая төгрөгийн 384 ажлыг гүйцэтгэхээр төлөвлөж, АИТХ-ын 2017 оны 12 сарын 01-ний 09 дүгээр тогтоолоор тодотгон баталсан байна. Үүнд: Хөрөнгө оруулалтын 202 ажлын 10607.8 сая төгрөг, шилжих үлдэгдлээр санхүүжигдэх 136 ажлын 6985.8 сая төгрөг, Байгаль хамгаалах арга хэмжээний хөрөнгө оруулалтаар 39 ажлын 752.8 сая төгрөг, Авто замын сангаар 7 ажлын 607.6 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тус тус батлагдсан байна. Нийт хөрөнгө оруулалтын 15.6 хувь буюу 2961.4 сая төгрөг нь төсөл хөтөлбөрийн зардал эзэлж байна.

Хөрөнгө оруулалтын ажлыг 2016 онтой харьцуулахад 23.4 хувиар буурсан байна. Дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулбал:

д/д	Ажлын төрөл	2016 онд батлагдсан ажил		2017 онд батлагдсан ажил	
		Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
1	Цахилгаан эрчим хүч нэмэгдүүлэх ажил	18	2029.4	30	1178.4
2	Авто засвар шинэчлэлийн ажил	8	1247.2	33	1709.4
3	Инженерийн шугам сүлжээний шинэчлэлт, засварын ажил	43	5856.2	20	1661.5
4	Байгаль орчин, ногоон байгууламж, тохижилтын чиглэлээр хийх ажил	26	679.5	39	752.7
5	Барилга засварын ажил	89	10169.2	73	7839.2
6	Бараа худалдан авах	43	2551.8	44	1643.6
7	Төсөл хөтөлбөр			136	2961.6
8	Бусад, зөвлөх үйлчилгээ	36	1587.5	1	600.0
9	Авто замын сангаар	8	637.1	8	607.7
10					
Нийт ажлын дүн		271	24757.9	384	18954.1

Гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын 201 ТАХ-нд 6771.2 сая төгрөг, болзошгүй аваарын зардалд 852.5 сая төгрөг, зураг төсвийн зардалд 495.1 сая төгрөг, техник хяналтын зардалд 208.9 сая төгрөг, төсөл хөтөлбөрт 1905.1 сая төгрөг, шилжих үлдэгдлээр санхүүжигдэх хөрөнгө оруулалтын 101 ТАХ-нд 4473.7 сая төгрөг, төсөл хөтөлбөрт 699.7 сая төгрөг, байгаль хамгаалах арга хэмжээний хөрөнгө оруулалтаарх 5 ТАХ-нд 222.2 сая төгрөг, төсөл хөтөлбөрт 254.7 сая төгрөг, авто замын сангаар 7 ТАХ-нд 552.2 сая төгрөг, нийт 16435.5 сая төгрөг зарцуулагдсан байна.

№	Ажлын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Орон нутгийн хөрөнгө оруулалт	10607.8	10232.8	375.0
2	Авто замын сан	607.6	552.2	55.4
3	Байгаль хамгаалах сан	752.8	476.9	275.9
4	Шилжих үлдэгдлээс санхүүжих	6985.8	5173.4	1812.4
5	Нийт дүн	18954.1	16435.3	2518.8

2017 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан ажлуудаас дараах ТАХ-нд санхүүжилт огт олгогдоогүй байна.

№	ТАХ-ний нэр	Гэрээний хугацаа	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Зөрүү	Гүйцэтгэгч байгууллага
1	Эрдэнэ багийн 11 цэцэрлэгийг уурын зуухтай болгох	10/19-11/05	35.0	29.8	5.2	"Бурхууд" ХХК
2	БОЭТ-д гемодиализын аппарат	11/27-12/05	75.0	72.8	2.2	"Нарт эрдэнэс" ХХК
3	"Чөлөөт цагийн талбай" дэд хөтөлбөрийн хүрээнд согоот багт 6-9 байрны урд талбай байгуулах	8/07-9/05	33.0	33.0		"Золотое руна" ХХК
4	Хотын доторх жижиг хогийн сав хийх	06/22-9/25	50.0	50.0		"Шигшмэл эрдэнэ" ХХК
5	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эргэлтийн авто машин	8/10-8/25	60.0	60.0		иргэн Т.Баянбат
6	Консулын БУХ-55 худгаас БУХ 56 худаг хоорондох шугам	07/08-12/14	7.3	7.3		"Сайн цонх" ХХК
7	Эрдэнэ багийн баян талын карьер сэргээх 1-р хэсэг	11/02-12/10	74.6	74.0	0.6	"Эм өү ди би" ХХК

8	Эрдэнэ багийн баян талын карьер сэргээх 2-р хэсэг	11/28-12/10	90.6	90.5	0.1	“Олз мандал” ХХК
9	Оюут багийн нутаг дэвсгэрт шинээр 35/6 кв-ын 2х630 кВА дэд өртөө барих зураг төсөвийн зөвлөх үйлчилгээ	09/07-12/20	10.2	10.2		“Ролби” ХХК
10	4-р цэцэрлэгийн засварын материалын зардал /халаах хэрэгслийн хаалт/	10/02-10/15	3.7	3.7		“Хөгжлийн тамга” ХХК
	Дүн		439.4	431.3	8.1	

Эрдэнэ багийн 11 цэцэрлэгийн гадна ИШС-ний ажлыг хийж гүйцэтгэсэн ч Хөрөнгө оруулалтын жагсаалтад Уурын зуухтай холбох гэж батлагдсан байсан тул нэр зөрүүтэй, санхүүжилт олгогдоогүй байна. Согоот багийн 6-н 9-р байрны урд чөлөөт цагийн талбай байгуулах ажил гэрээ хийгдэж, талбайн суурь тавих газар шорооны ажил хийгдэж он дамжсан. Хотын доторх жижиг хогийн сав хийх ажлын гэрээ хийгдэж, хогийн саваа хийсэн ч цаг агаар хүйтэрч, суурилуулах ажил хойшлогдсон. ӨЭМТ-ийн авто машин гэрээт хугацаандаа нийлүүлэгдсэн ч баримт бичгийн бүрдэл дутуу байснаас он дамжсан. ОХУ-н Консулын БУХ55 худгаас БУХ56 худаг хоорондох шугамын ажил хийгдсэн ч улсын комисс ажиллуулахаар хүлээгдэж байгаа, Баян талын карьер нөхөн сэргээх ажил, “Оюут багийн нутаг дэвсгэрт шинээр 35/6 кв-ын 2х630 кВА дэд өртөө барих” зураг төсвийн ажил, 4-р цэцэрлэгийн засвар /халаах хэрэгслийн хаалт/ зэрэг ажлууд гэрээ хийгдэж ажил эхэлсэн ч он дамжин хэрэгжиж байна.

Болзошгүй аваарын зардлаас 385.4 сая төгрөгийг байрны дээврийн засварт, 222.5 сая төгрөгийг хотын доторх замын нөхөөс, багуудад хайрган шороон зам сайжруулах ажилд, 106.5 сая төгрөгийг малын гоц халдварт цэцэг, шүлхий өвчнүүдээс урьдчилан сэргийлэх зорилгоор малыг вакцинжуулах ажил, гэр хорооллын үерийн даланг ухаж сэргээх, шинээр татах, Эрдэнэ багт болсон үерийн улмаас үүссэн гамшгийн нөхцөл байдлыг арилгах, замын цас цэвэрлэх зэрэг ажлуудад, 138.0 сая төгрөгийг бусад урсгал засварын ажлуудад зарцуулсан байна. Болзошгүй аваарын зардлын 45.2 хувийг байрны дээврийн засварт зарцуулсан байна.

№	Ажлын нэр	2016 онд		2017 онд	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл
1	Болзошгүй аваарын зардал	1269.3	1249.8	843.5	852.4

2017 оны болзошгүй аваарын зардлыг 2016 онтой харьцуулахад 33.5%-иар буурсан байна.

АИТХ-ын 2017 оны 12 сарын 01-ний 09 тогтоолоор Болзошгүй аваарын зардлыг 843.5 сая төгрөгөөр төлөвлөн батлагдсан байхад гүйцэтгэлээр Засаг даргын 19 удаагийн захирамжаар 852.4 сая төгрөг гаргаж 8.9 сая төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан зөрчил илэрлээ. Болзошгүй аваарын зардлыг захиран зарцуулах журмын 3.4-т заасан “Болзошгүй аваарийн зардлаас зардал гаргах зайлшгүй шаардлага гарсан нөхцөлд хариуцагч хуулийн этгээд ажилтан шаардлагатай бол тухайн тойргийн төлөөлөгч нь уг арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө, ОБГ-ын байцаагчийн дүгнэлт, МХГ-ын байцаагчийн дүгнэлт төсвийн зардлын зүйлээр хийсэн дэлгэрэнгүй тооцооны хамт ХЗА-нд ирүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Бүлэг 3. Хөрөнгө оруулалтын өгөөжийг бодитой тооцож, үнэлээгүй байна.

3.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл хөтлөлт хангалттай, ашиглалт 97.7 хувьтай байна.

2017 оны хөрөнгө оруулалтаар хийгдсэн 236 ТАХ-ний 13595.9 сая төгрөгийн хөрөнгийг санхүүгийн тайланд бүртгэхээс орон нутгийн өмчийн газар нь 13595.9 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн буюу бүртгэл хөтлөлт 100 хувьтай байна.

Үүнд 1278.9 сая төгрөгийн нийтийн эзэмшлийн хөрөнгө, 3945.6 сая төгрөгийн барилга байгууламж, их засвар, 970.5 сая төгрөгийн авто зам гүүр, үер усны далан, 5961.5 сая төгрөгийн дуусаагүй барилга, 1913.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, эд хогшил бүртгэгдсэн байна. Мөн шилжих үлдэгдлээр хийгдэж дууссан 10 барилга засварын ажлын 2620.8 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн байна.

Хөрөнгө оруулалтын дүнд бий болсон 310.7 сая төгрөгийн хөрөнгө одоогоор ашиглагдаагүй байна. Үүнд:

- Гэр хорооллын айл өрхүүдийг инженерийн шугам сүлжээнд холбох ажлын хүрээнд 299.2 сая төгрөгөөр Рашаант, Наран, Уртын гол багуудад бохир усны 885 м, цэвэр усны 925 м шугамын ажлыг хийж дууссан, улсын комисс хүлээн авсан боловч ашиглалт хангагдаагүй байна.
- БОЭТ-ийн эрэгтэйчүүдийн кабинетийг шинээр тохижуулах ажил дуусч хүлээн авсан боловч одоо хүртэл ашиглагдаагүй.



БОЭТ-ийн эрэгтэйчүүдийн кабинет

- Эрдэнэт ШУТПарк нь хөрөнгө оруулалтаар авсан нэг бүр нь 1550.0 мянган төгрөгийн, нийт 4650.0 мянган төгрөгийн 3 суурин компьютер, 1150.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, 370.0 мянган төгрөгийн HP-1102 лазер принтер зэрэг нийт 6170.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг ашиглаагүй агуулахад хадгалагдаж байна. Одоогоор орон тоо бүрэн батлагдаагүй байгаа тул техник тоног төхөөрөмжүүд ашиглагдаагүй байна.



Ашиглагдаагүй, хадгалж буй тоног төхөөрөмжүүд

3.2 Хөрөнгө оруулалтад дотоод хяналт хийгдээгүй, эрсдлийн удирдлагаар хангагдаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын алба төсвийн хөрөнгө, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдлийн удирдлагаар хангаж ажиллахаар заасан бөгөөд Орхон аймгийн ТЕЗ-ийн дотоод хяналтыг аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба хэрэгжүүлж байна.

Тус алба нь 2017 оны орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд хяналт хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байсан ч хэрэгжүүлээгүй байна.

2016 оны ОНХО-ын аудитаар дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх тухай зөвлөмж өгсөн ч зөрчил дахин давтагдсан байх тул Санхүүгийн хяналт аудитын албанд хөрөнгө оруулалтын ажилд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

3.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, үр өгөөжийг бодитой тооцож, үнэлж дүгнэх шаардлагатай байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Орхон аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс тооцон, биелэлтийг гарган ажиллаж байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 304 арга хэмжээний биелэлтийг дүгнэсэн бөгөөд үүнээс 75 нь хөрөнгө оруулалттай холбоотой, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 256 арга хэмжээний биелэлт дүгнэсний 46 нь хөрөнгө оруулалттай холбоотой арга хэмжээний биелэлтийг дүгнэн, хувьчилж гаргасан байна.

Хөрөнгө оруулалтын ажлууд үр дүнтэй, үр өгөөжтэй болж байгаа эсэхийг тооцдоггүй учир тэдгээрээс бий болсон үр өгөөж тодорхой бус, хөрөнгө оруулалтын ажил зорьсон хэмжээнд хүрч чадсан эсэх, үр дүн хэрхэн гарсан, цаашид ижил төрлийн хөрөнгө оруулалтад ямар үр өгөөж гарах зэрэг нь тодорхой бус байна.

Иймд цаашид хөрөнгө оруулалтаас бий болох үр өгөөжийг төлөвлөн, гарсан үр өгөөжийг бодитоор тооцох шаардлагатай байна.

Өмнөх онд хийгдсэн гүйцэтгэлийн аудитын дүнгээр 15 зөвлөмж, 766.6 сая төгрөгийн 8 албан шаардлага, 90.4 сая төгрөгийн 4 төлбөрийн актыг холбогдох байгууллага албан тушаалтанд хариуцуулан өгөгдсөн бөгөөд 14.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 689.1 сая төгрөгийн 5 албан шаардлага, 10 зөвлөмж хэрэгжсэн байна. 27.6 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 63.3 сая төгрөгийн 1 албан шаардлагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн болно.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Хөрөнгө оруулалтын үр өгөөжийг төлөвлөн, захиалагчийн болон дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлж, бий болсон үр өгөөж, үр дүнг бодитой тооцох шаардлагатай байна.

Дээрх дүгнэлтэд үндэслэн Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ХББЗА ОНӨААТҮГ-т зөрчил арилгах 1 албан шаардлага, Орон нутгийн өмчийн газарт 2 албан шаардлага, Баян-Өндөр сумын ИТХ-д 1 албан шаардлага, Санхүүгийн хяналт, аудитын албанд дотоод хяналт хэрэгжүүлэх албан шаардлагыг тус тус хүргүүлж, зөвлөмжийг холбогдох байгууллагуудад тайлангаар хүргүүлж байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн ИТХ-д:

- Зураг төсөвгүй ажилд хөрөнгө батлахгүй байх.

Аймгийн ЗДТГазрын СТСХэлтэст:

- Болзошгүй аваарын зардлаас санхүүжүүлэх ТАХ-нд санхүүжилт олгохдоо батлагдсан төсөвт багтаан зарцуулах.

Аймгийн ЗДТГ-т:

- Хөрөнгө оруулалтын ТАХ-ний ач холбогдол, хүрэх үр дүнг төлөвлөн, бий болсон үр дүн, үр өгөөжийг бодитой тооцох,
- Хөрөнгө оруулалтын санхүүжилтаар тоног төхөөрөмж авахдаа зах зээлийн бодит үнээр худалдан авах, өндөр үнээр хөрөнгө бэлтгэхгүй байх.

Орон нутгийн өмчийн газарт:

- Хөрөнгө оруулалтын санхүүжилтаар тоног төхөөрөмж авахдаа зах зээлийн бодит үнээр худалдан авах, өндөр үнээр хөрөнгө бэлтгэхгүй байх.

Хотын захирагчийн алба, ХББЗА ОНӨААТҮГ-т:

- Өмнөх онуудад үр ашиггүй болж байсан зураг төсвийг дахин ашиглахгүй байх, зураг төсөв хийгдэж батлагдсан он, сар, өдрийг бичиж баталгаажуулж байх.

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ЭРДЭНЭ

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР
АУДИТОРО.ДАШЖАМЦ
О.ГАНТУЯА

Хавсралт № 01

“Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” гүйцэтгэлийн аудитаар илэрсэн төлбөр зөрчлийн жагсаалт

/сая.төгрөг/

Актын дугаар	Зөрчлийн товч утга	Төлбөр хариуцагч байгууллага	Төлбөр хариуцагчийн		Төлбөр	Зөрчил
			Албан тушаал	Нэр		
	Ажлын чанар хангалтгүй гүйцэтгэсэн 7 ажлыг гүйцэтгэгч байгууллагаар дахин гүйцэтгүүлэх	ХББЗА ОНӨҮГ	Захирал	Б.Мөнхдалай		491.3
	Орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд дотоод хяналт хэрэгжүүлээгүй	Санхүүгийн хяналт аудитын алба	Дарга	Д.Сайзмаа		
	<p>•350.0 сая, 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, нийт 500 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Гэр хорооллын үерийн хамгаалалтын суваг хийх" 2 ажил дээр хуульд нийцэх шалтгаангүйгээр хязгаарлалттай тендер шалгаруулалт явуулж ТБОНӨХБАҮХАТХуулийн 8.2 дахь "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ" гэсэн заалтыг зөрчсөн,</p> <p>•165.3 сая төгрөгийг төсөвт өртөг бүхий "Эрдэнэ багийн Баян талын карьерийг нөхөн сэргээх" ажлын тендерийг 2 хуваан, харьцуулалтын аргаар явуулж ТБОНӨХБАҮХАТХуулийн 8.5 дахь "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн.</p> <p>•Тус бүр нь 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, нийт 450.0 сая төгрөгийн төсөв бүхий "Орон сууцны хорооллуудад хогийн сав хийх" 9 ажилд үнийн санал ирүүлэх урилга илгээгээгүй, ТБОНӨХБАҮХАТХуулийн 33.2.1 дэх "техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх" гэсэн заалтыг зөрчсөн.</p>	Орон нутгийн өмчийн газар	Дарга	Л.Оюунгэрэл		950.0
	Санхүүгийн тайланд бүртгэлтэй байгаа 31 Ирад-ийг хуучин төлөөлөгчдөөс эргүүлэн авах	Баян-Өндөр сумын ИТХ	Дарга	Б.Баасансүрэн		40.3
	Нийт дүн					1481.6



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 01/ГАГ-ОАТАГ-2018-01-ГА Эрдэнэт хот

Г ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэсэн “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Тус бүр нь 350.0 сая, 150.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Гэр хорооллын үерийн хамгаалалтын суваг хийх” 2 ажилд хязгаарлалттай тендер шалгаруулалт явуулсан,
- Тус бүр нь 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, нийт 450.0 сая төгрөгийн төсөв бүхий “Орон сууцны хорооллуудад хогийн сав хийх” 9 ажилд үнийн санал ирүүлэх урилга илгээгээгүй байна.

Дээрх зөрчлүүд нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 8.2-т “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”, 33.2.1-т “техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-т “...дараах алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө”, 4.1.7-д “Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Аудитаар илэрсэн дээрх зөрчлүүдийг арилган, дахин давтахгүй байж, биелэлтийг 2018 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын дарга Л.Оюунгэрэлд хариуцуулан даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТОР



О. ДАШЖАМЦ

О. ГАНТУЯА

ЗӨВШӨӨРСӨН:

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГА

Л.ОЮУНГЭРЭЛ



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 72/ЭЗ-ГАГ-ОАТАГ-2018-01-ГА Эрдэнэт хот

Г ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ 7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэсэн “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Засаг даргын шууд удирдлаганд дотоод аудитын үйл ажиллагаа эрхлэх чиг үүрэг бүхий Санхүүгийн хяналт аудитын алба нь 2017 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтанд дотоод аудит хийх төлөвлөгөөтэй байсан ч хөрөнгө оруулалтын төлөвлөлт, зарцуулалт, хөрөнгийн бүртгэл, ашиглалтанд хяналт тавиагүй байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 14.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 69.1-т “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-т “...дараах алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө”, 4.1.7-д “Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

2018 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргаж, эрсдэлийн удирдлагаар ханган, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаж, биелэлтийг 2018 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Орхон аймаг

дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Санхүүгийн хяналт аудитын албаны дарга Д.Сайзмаад хариуцуулан даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

АУДИТОР

АУДИТОР



О.ДАШЖАМЦ

О.ГАНТУЯА

ЗӨВШӨӨРСӨН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН
АЛБАНЫ
ДАРГА



Д.САЙЗМАА

¹Акт, албан шаардлагын биелэлт хангагдвэгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас төвөгсөн албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж зөвсн дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 71/71-1/АГ-ОАТАГ-2018-01-ГА Эрдэнэт хот

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэсэн “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Гэр хорооллын 3 дугаар сургуулийн засварын ажлын шалны хулдаас зураг төсөвт тусгаагүй материалаар хийсэн, 2 давхарын коридорын бетон цутгалт хийгдээгүй хулдаасны наалт муу хийгдсэн,
- Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн засварын ажлын хананд шалны плита наасан, шаланд хог тогтдог нүхтэй плита наасан, усны хаялгыг сайн гаргаагүй,
- 17-р сургуулийн гадна биеийн тамирын талбайг бүрэн тохижуулах ажлын гар бөмбөгийн талбайн ус зайлуулагч нь бөглөрсөн, явган хүний шатны 2 тал нь эмтэрсэн,
- Орхон цогцолбор сургуулийн гадна биеийн тамирын талбайд хиймэл зүлэг бүхий хөлбөмбөгийн талбай байгуулах ажлын хиймэл зүлэг бүхий хөлбөмбөгийн талбайд ус зайлуулагч хийгдээгүй, тэмдэглэгээний цагаан наалтууд хуурч алга болсон,
- 8 ширхэг автобусны зогсоол, сүүдрэвч барих ажлын сүүдрэвчний сурталчилгааны самбар болон гэрэлтүүлэг нь хагарсан,
- 1-14 байрны 2 блок, 4-10 байрны 3 блокын дээврийн засварын ажлын дээврээс ус гоожсон байна.

Дээрх зөрчил нь Барилга захиалагчийн дүрмийн 3.1.4.-т “Гүйцэтгэгч нь барилга байгууламжийн үе шатны ажлыг гүйцэтгэх явцад зураг төсөл, барилгын норм, дүрэм, техникийн нөхцлийг зөрчиж, чанаргүй болон дутуу гүйцэтгэсэн тохиолдолд түүнийг гүйцэтгэгчийн зардлаар засуулах, нөхөн хийлгэх, санхүүжилтийг зогсоох, учирсан хохирлыг төлүүлэх арга хэмжээ авах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын

Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д “...дараах алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө”, 4.1.7-д “Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

Аудитаар чанарын доголдолтой гүйцэтгэсэн дээрх ажлуудыг гүйцэтгэгч байгууллагаар дахин гүйцэтгүүлж, ажлын чанар үр нөлөөг дээшлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч, биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 25-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ХББЗА ОНӨААТҮГ-ын дарга Б.Мөнхдалайд хариуцуулан даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

АУДИТОР

АУДИТОР



О.ДАШЖАМЦ

О.ГАНТУЯА

ЗӨВШӨӨРСӨН:

ХББЗА ОНӨААТҮГ-ЫН ДАРГА

Б.МӨНХДАЛАЙ



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдавгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас төвшин албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж зөвснө дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 702/ОА-ОАТАГ-2018-01-ГА

Эрдэнэт хот

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэсэн “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Баян-Өндөр сумын ИТХ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 40.3 сая төгрөгийн дүн бүхий 31 ширхэг зөөврийн таблет /IPad/ биетээр байхгүй байна.

Дээрх зөрчил нь НББ-ийн тухай хуулийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-т “...дараах алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө”, 4.1.2-т “Өмч, хөрөнгийг зохих шийдвэргүйгээр бусдад зүй бусаар ашиглуулсан зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Биетээр байхгүй байгаа хөрөнгийг буцаан авч, тооллогоор үлдэгдлийг баталгаажуулан, биелэлтийг 2018 оны 10 дугаар сарын 25-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баян-Өндөр сумын ИТХ-ын дарга Б.Баасансүрэн, нягтлан бодогч Д.Эрдэнэ-Очир нарт хариуцуулан даалгав.

702 0 0 0 0

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

АУДИТОР

АУДИТОР

О.ДАШЖАМЦ

О.ГАНТУЯА



ЗӨВШӨӨРСӨН:

БАЯН-ӨНДӨР СУМЫН ИТХ-ЫН ДАРГА

НЯГТЛАН БОДӨГЧ

Б.БААСАНСҮРЭН

Д.ЭРДЭНЭ-ОЧИР



¹ Алт, албан шаардлагын биелэлт хангагдавгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас төвшин албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны бөгөөд харууцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.